

МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
ХИЙСЭН ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2014 оны 06 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2014 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хийлгээ.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, Л.Энх-Амгалан нар төсөл санаачлагч болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах яамдын сайд нараас асуулт асууж, хариулт авсан болно.

Хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл хангартгүй байгаа шалтгааныг олж тогтоох, нийгмийн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, царцаасан объектын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Байнгын хорооны ажлын хэсэг гаргаж ажиллуулах, Худалдан авах ажиллагааны газрын ачааллыг бууруулах, Үндэсний аудитын газрыг бие даасан, хараат бус байлгах, валютын ханшны зөрүүнээс гарах алдагдлыг тооцож, дүгнэлт гаргуулах; Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан 2013 оны төсвийн гүйцэтгэл тасарч байгаа шалтгааныг тодруулах, улсын төсвийг захиран зарцуулах асуудлаар яамны чадавхийг тодорхойлох, улсын төсвийн гадуурх Чингис бонд, Самурай бонд, Хөгжлийн банкны санхүүжилтэнд аудитын дүгнэлт гаргуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, албан тушаалаа хэтрүүлэн албаны машин унасан, худалдан авсан албан тушаалтанд хариуцлага тооцох, Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын харьяа байгууллагын хувьд хөндлөнгийн хараат бус, бие даасан дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын 34 дүгээр тогтоол, Засгийн газрын 147 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газарт үүрэг болгох зэрэг саналуудыг гаргасан болно.

Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлэг хийсэн талаар Байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Төсвийн зарлагын дэд хороонд хүргүүлж байна.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.БАТЦОГТ



Хоёр дахь хэлэлцүүлэгт
2014.06.27

**МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН
ҮЕЭР УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэмжсэн санал:

1.Улсын төсөвт ашиглах төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтсон аргачлал эх сурвалжид үндэслэн тооцох

2.Улсын Их Хурлын Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 34 дүгээр тогтоол болон Засгийн газрын Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай 147 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газарт үүрэг болгох.

**Санал гаргасан: Ё.Отгонбаяр, Д.Сарангэрэл, Л.Энх-Амгалан,
А.Тлейхан, О.Содбилэг, Я.Содбаатар, Д.Сумъяабазар**

3.Ерөнхий сайдын зарцуулсан 50 тэрбум төгрөг, “Гудамж” төслийн 47 тэрбум төгрөг, Чингис бондын эргэн төлөгдөхгүй нөхцлөөр зарцуулж буй хөрөнгийн хэсэгт санхүүгийн гүйцэтгэлийн болон үр дүнгийн аудит хийлгэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Нямдорж,
А.Тлейхан, Л.Энх-Амгалан, Ё.Отгонбаяр**

4.Улсын Их Хурлын 2012 оны 60 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 28.8 дахь заалтын хэрэгжилтийг хангуулах, хариуцлага албан тушаалтанд хариуцлага тооцох.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Нямдорж,
А.Тлейхан, Л.Энх-Амгалан, Ё.Отгонбаяр**

Хоёр. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос дэмжигдээгүй санал:

1.Санхүүгийн хяналтыг сулруулж, өр авлагыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарт хариуцлага тооцох

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Нямдорж,
А.Тлейхан, Л.Энх-Амгалан, Ё.Отгонбаяр**

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ БАЙНГЫН ХОРОО**